



МОНГОЛ УЛС  
ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН  
ТОГТООЛ

2019 оны 9 сарын 26 өдөр

Дугаар 85

Улаанбаатар хот

Зөвшөөрөл олгох тухай

Төрийн албаны тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.4 дэх хэсэг, “Аймгийн засаг даргын Тамгын газрын бүтцийг шинэчлэн тогтоох тухай” Засгийн газрын 2016 оны 9 дүгээр тогтоолын 4 дэх заалт, “Төрийн захиргааны албан тушаалын ангилал, зэрэглэл, жагсаалт батлах тухай” Засгийн газрын 2019 оны 275 дугаар тогтоол, Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 03 дугаар тогтоолоор баталсан “Албан тушаалын тодорхойлолт боловсруулах нийтлэг журам”-ын 4.1, 4.2 дахь заалтыг тус тус үндэслэн Завхан аймгийн Эрүүл мэндийн газрын төрийн захиргааны албан хаагчдын албан тушаалын тодорхойлолтыг хянан хэлэлцээд ТОГТООХ нь:

1.Завхан аймгийн Эрүүл мэндийн газрын Нийгмийн эрүүл мэндийн төвийн Сум, өрхийн эрүүл мэндийн төвийн тусламж үйлчилгээ хариуцсан мэргэжилтний албан тушаалын тодорхойлолтыг 1 дүгээр, Нөхөн үржихүйн эрүүл мэнд хариуцсан мэргэжилтний албан тушаалын тодорхойлолтыг 2 дугаар, Өсвөр үе, залуучууд, ахмад настны эрүүл мэнд хариуцсан мэргэжилтний албан тушаалын тодорхойлолтыг 3 дугаар, Орчны эрүүл мэнд, эрүүл мэндийн нөлөөллийн үнэлгээ хариуцсан мэргэжилтний албан тушаалын тодорхойлолтыг 4 дүгээр, Халдварт бус өвчний сэргийлэлт, хяналт хариуцсан мэргэжилтний албан тушаалын тодорхойлолтыг 5 дугаар, Сэтгэцийн эрүүл мэнд, осол гэмтлийн тандалт хариуцсан мэргэжилтний албан тушаалын тодорхойлолтыг 6 дугаар, Хоол тэжээл хүнсний аюулгүй байдал хариуцсан мэргэжилтний албан тушаалын тодорхойлолтыг 7 дугаар, Нийтийн биеийн тамир, чийрэгжүүлэлт хариуцсан мэргэжилтний албан тушаалын тодорхойлолтыг 8 дугаар, Эрүүл мэндийн боловсрол, сургалт сурталчилгаа хариуцсан мэргэжилтний албан тушаалын тодорхойлолтыг 9 дүгээр, Халдварт өвчний тандалт, сэргийлэлт хариуцсан мэргэжилтний албан тушаалын тодорхойлолтыг 10 дугаар, Халдварт өвчний бүртгэл мэдээлэл хариуцсан мэргэжилтний албан тушаалын тодорхойлолтыг 11 дүгээр, Эрүүл зүй, биеийн найрлага, орчин хор судлалын лаборатори хариуцсан мэргэжилтний албан тушаалын тодорхойлолтыг 12 дугаар, Эмнэлгийн тусламж үйлчилгээний хэлтсийн Эмнэлгийн тусламж үйлчилгээний чанар, эрсдэл, цус цусан бүтээгдэхүүний аюулгүй байдал хариуцсан мэргэжилтний албан тушаалын тодорхойлолтыг 13 дугаар, Эмнэлгийн магадлан итгэмжлэл, тусгай зөвшөөрөл, оношлогоо эмчилгээний технологи, эмнэлгээс шалтгаалах халдвар хариуцсан мэргэжилтний албан тушаалын тодорхойлолтыг 14 дүгээр, Эх барих эмэгтэйчүүдийн тусламж үйлчилгээ хариуцсан мэргэжилтний албан тушаалын тодорхойлолтыг 15 дугаар, Хүүхдийн тусламж үйлчилгээ хариуцсан мэргэжилтний албан тушаалын

ТАЗ тогтоол 2019

тодорхойлолтыг 16 дугаар, Уламжлалт анагаах ухаан, сэргээн засах тусламж үйлчилгээ хариуцсан мэргэжилтний албан тушаалын тодорхойлолтыг 17 дугаар, Эмийн чанар аюулгүй байдал, эмийн зохистой хэрэглээ хариуцсан мэргэжилтний албан тушаалын тодорхойлолтыг 18 дугаар, Яаралтай гамшиг, эрсдлийн үеийн тусламж үйлчилгээ хариуцсан мэргэжилтний албан тушаалын тодорхойлолтыг 19 дүгээр, Сувилахуй болон хөнгөвчлөх тусламж үйлчилгээ хариуцсан мэргэжилтний албан тушаалын тодорхойлолтыг 20 дугаар, Удирдлага төлөвлөлт санхүүгийн хэлтсийн Эрүүл мэндийн эдийн засаг, төсвийн төлөвлөлт хариуцсан мэргэжилтний албан тушаалын тодорхойлолтыг 21 дүгээр, Салбарын санхүүгийн бүртгэл мэдээлэл, байгууллагын нягтлан бодох бүртгэл хариуцсан мэргэжилтний албан тушаалын тодорхойлолтыг 22 дугаар, Хүний нөөцийн төлөвлөлт, хангалт сургалт, мэргэжлийн зөвшөөрөл хариуцсан мэргэжилтний албан тушаалын тодорхойлолтыг 23 дугаар, Эрүүл мэндийн ажилтны нийгмийн асуудал, шагнал урамшуулал хариуцсан мэргэжилтний албан тушаалын тодорхойлолтыг 24 дүгээр, Хууль эрх зүйн зөвлөгөө хариуцсан мэргэжилтний албан тушаалын тодорхойлолтыг 25 дугаар, Эм, эмнэлгийн хэрэгслийн хангамж хариуцсан мэргэжилтний албан тушаалын тодорхойлолтыг 26 дугаар, Хөрөнгийн бүртгэл, хөрөнгө оруулалтын төлөвлөлт, барилга байгууламж хариуцсан мэргэжилтний албан тушаалын тодорхойлолтыг 27 дугаар, Хяналт-шинжилгээ, үнэлгээ мэдээллийн хэлтсийн Эрүүл мэндийн статистик мэдээ, мэдээлэл хариуцсан мэргэжилтний албан тушаалын тодорхойлолтыг 28 дугаар, Хяналт шинжилгээ үнэлгээ, дотоод аудит хариуцсан мэргэжилтний албан тушаалын тодорхойлолтыг 29 дүгээр, Мэдээллийн технологи, телемедицин хариуцсан мэргэжилтний албан тушаалын тодорхойлолтыг 30 дугаар, Эрүүл мэндийн мэдээний сан хариуцсан мэргэжилтний албан тушаалын тодорхойлолтыг 31 дүгээр хавсралт ёсоор тус тус батлахыг тус аймгийн Эрүүл мэндийн газрын дарга /Ч.Дэмчигсүрэн/-д зөвшөөрсүгэй.

2.Хянаж зөвшөөрөл олгосон албан тушаалын тодорхойлолт тус бүрийг албажуулах, баталж мөрдүүлэх, нэгдсэн санд бүртгэх үйл ажиллагааг мэргэшил, арга зүйн зөвлөгөөгөөр хангаж ажиллахыг Ажлын алба /Б.Алтанзул /-нд даалгасугай.

3.Зөвшөөрөл олгосон албан тушаалын тодорхойлолтыг эрх бүхий албан тушаалтнаар батлуулж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн албаны зөвлөлийн Завхан аймаг дахь салбар зөвлөл /Л.Лхамсүрэн/-д үүрэг болгосугай.

ДАРГА



Б.БААТАРЗОРИГ